



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

до23 оны 10 сарын 10 өдөр

Дугаар Б1648

Улаанбаатар хот

Ш.Очирсүрэнд сахилгын шийтгэл  
ногдуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5 дахь заалт , Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 27 дугаар зүйлийн 27.4.3 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1.1, 48.4 дэх хэсэг, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.7 дахь заалт, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2022 оны А/1300 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Улсын бүртгэлийн байгууллагын Хөдөлмөрийн дотоод журам”-ын 10.4, 10.7 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:


1. Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн хуулийн этгээдийн улсын бүртгэгч Шаравжамцын Очирсүрэн хууль, тогтоомжид заасан үүргээ биелүүлээгүй нь Хяналт шалгалтын газрын 2023 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 5909 дугаартай улсын байцаагчийн дүгнэлт, холбогдох бусад нотлох баримтаар тогтоогдсон тул түүнд 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Өдөр тутмын үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийг мөрдөж, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газар /Г.Анхныбаяр/, Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн хуулийн этгээдийн улсын бүртгэгч Ш.Очирсүрэнд үүрэг болгосугай.

3. Албан хаагчдад ажлын хариуцлага, дэг журмыг чанд сахин ажиллахыг анхааруулж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газар /Г.Анхныбаяр/, Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс /Д.Оюунбилэг/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Г.Цолмон/-т үүрэг болгосугай.

4. Энэ тушаалыг эс зөвшөөрвөл тушаалыг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор төрийн албаны төв байгууллагад гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГА



Д.ДЭЛГЭРСАЙХАН

142304403